

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын авто замын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/14/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Улаанбаатар хот 2024 он	Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ж.Энхтуяа Утас: 261628 Цахим хаяг: enkhtuyaj@audit.gov.mn
	Аудитор: Н.Нямсүрэн Утас: 261628 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД ТАНАА

2024.03.25 № 071841
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улсын авто замын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын авто замын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 36,473,174.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 23,838,991.9 мянган төгрөг, нийт 60,312,166.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, хөрөнгийн зардалд 55,252,947.9 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны зардалд 4,998,441.9 мянган төгрөг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 58,118.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 222 дугаар тогтоол "Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээ"-ний дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч буй олон улсын тээврийн хэрэгслээс төлбөр авах үйл ажиллагааг 2023 оны 11 дүгээр сараас эхлэн зохион байгуулж, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 162 тээврийн хэрэгслээс 58,100.0 мянган төгрөг, "Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламж ашиглан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн задрах боломжгүй ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээ"-ний дагуу 2023 оны 10 дугаар сараас эхлэн задрах боломжгүй ачаа тээвэрлэлтээс 303,800.0 мянган төгрөг, нийт

361,900.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг шинээр авто замын санд төвлөрүүлэн ажилласан байна.

Тайлант онд тус сангийн орлогын төлөвлөгөөг 34 төлбөр хураах цэгээр дамжуулан 10,466,607.5 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, 16,979,410.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төслийн тайлант жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндсэн 3 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,739,515.5	6,347,335.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	281,738.5	301,807.7
33	АВЛАГА	9,739.0	2,970.2
34	УРЬДЧИЛГАА	875,156.8	775,156.8
35	БАРАА МАТЕРИАЛ	99,315.6	64,244.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	3,473,565.5	5,203,156.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,204,884.7	5,970,807.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,944,400.2	12,318,143.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	520,936.2	1,141,638.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,423,464.0	11,176,504.4
51	Засгийн газрын хувь оролцоо	10,423,464.0	11,176,504.4
51200	Хуримтлагдсан үр дүн	10,038,912.6	10,791,953.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	384,551.4	384,551.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,944,400.2	12,318,143.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	55,676,675.4	60,470,113.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,576,675.4	23,996,938.9
120	Нийтлэг татварын бус орлого	13,576,675.4	23,996,938.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	42,100,000.0	36,473,174.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,006,895.8	5,574,235.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,006,895.8	5,574,235.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,932,973.8	5,455,856.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,014,963.0	3,569,038.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	379,727.7	449,972.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	184,413.8	209,481.4
2104	Хангамж, бараа материалын зардал	179,631.1	256,882.8
2105	Нормативт зардал	135,709.9	25,125.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	204,794.3	214,355.8
2107	Томилолт, зочны зардал	22,602.9	37,645.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	446,473.6	298,832.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	364,657.5	394,521.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,922.0	118,379.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	50,669,779.6	54,895,878.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	47,757,025.0	54,142,838.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,912,754.6	753,040.5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	55,676,675.4	60,312,287.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,576,675.4	23,839,112.7
120	Нийтлэг татварын бус орлого	13,576,675.4	23,839,112.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	42,100,000.0	36,473,174.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,841,649.5	5,008,929.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,841,649.5	5,008,929.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,841,649.5	4,968,113.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,841,649.5	4,968,100.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	40,816.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	50,835,025.9	55,303,358.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	50,779,857.2	55,283,288.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,779,857.2	55,283,288.9
2200	Дотоод эх үүсвэрээр	50,779,857.2	55,283,288.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(50,779,857.2)	(55,283,288.9)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	55,168.7	20,069.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	226,569.8	281,738.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	281,738.5	301,807.8

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,510,709.3	-	7,510,709.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,510,709.3	-	7,510,709.3
9	Тайлант үеийн үр дүн	2,912,754.6	-	2,912,754.6
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,423,464.0	-	10,423,463.9
19	Тайлант үеийн үр дүн	753,040.5	-	753,040.5
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,176,504.4	-	11,176,504.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,473,174,900.00	60,251,389,830.60	(1,221,785,069.40)	98.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,000,000,000.00	4,998,441,927.70	(1,558,072.30)	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000,000,000.00	4,998,441,927.70	(1,558,072.30)	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000,000,000.00	4,998,441,927.70	(1,558,072.30)	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000,000.00	4,998,441,927.70	(1,558,072.30)	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,473,174,900.00	55,252,947,902.90	(1,220,226,997.10)	97.8
223001	Бусад хөрөнгө	56,473,174,900.00	55,252,947,902.90	(1,220,226,997.10)	97.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,473,174,900.00	60,302,549,672.34	(1,170,625,227.66)	98.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36,473,174,900.00	36,473,174,899.90	(0.10)	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	36,473,174,900.00	36,473,174,899.90	(0.10)	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	25,000,000,000.00	23,829,374,772.44	(1,170,625,227.56)	95.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,000,000,000.00	23,829,374,772.44	(1,170,625,227.56)	95.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	23,988,940.44	23,988,940.44	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	75,148,782.18	75,148,782.18	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	226,550,200.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	226,550,200.00

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 224,461.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 149,546.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 94,915.8 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, дахин давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

3.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Харьяа байгууллагын нийт дүн									
Төлбөр авах цэг	Нэмэлт санхүүжилтийн дансанд 2018 оноос хойш байршуулсан Сүхбаатар аймгийн Дарьганга сумын "Сумын төвийн хэсэгчилсэн 2.35 км хатуу хучилттай авто замын барилгын ажил"-ын 149,546.0 мянган төгрөгийн барьцааны хугацаа дууссан, замын барилгын ажлыг бүрэн хийгээгүй төлбөрийн асуудлыг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлсэн холбогдох арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.	1	149,546.0	1	149,546.0				
Төлбөр авах цэг	Тайлант онд хэвлэл мэдээллийн 2 байгууллагатай гэрээ байгуулж байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулахад зориулан 23,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	23,000.0			1	23,000.0		
Төлбөр авах цэг	Төлбөр авах цэг нь Веритас Партнерс ХХН-тэй Авто замын санд орлого төвлөрүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар судалгаа, дүгнэлт гаргахад хууль зүйн зөвлөгөө авах зорилгоор 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 2023/08-170 дугаартай 18,000.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий "Хууль зүйн туслалцаа үзүүлэх" гэрээ байгуулсан боловч гэрээнд заасан үйлчилгээг аваагүй байхад төлбөрийг бүрэн шилжүүлсэн байна.	1	18,000.0			1	18,000.0		

¹

Төлбөр авах цэг	Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, тоног төхөөрөмж зэрэг 32 нэр төрлийн 183 ширхэг 308,609.9 мянган төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.	1	-					1	-
Төлбөр авах цэгийн нийт дүн		4	190,546.0	1	149,546.0	2	41,000.0	1	-
Улсын авто замын сан	Тус байгууллага 2023 оны санхүүгийн тайлангаа хуулийн хугацааг 4 хоногоор хоцроож аудитын байгууллагад ирүүлсэн байна.	1	-			1	-		
Улсын авто замын сан	Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 210/МА2022/00930 дугаар шийдвэрээр тус сангийн 100900028054 дугаар дансанд орж ирсэн 6,822,962.6 мянган төгрөгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/167 дугаар тушаалаар Ховд АЗЗА ТӨХК-д Ховд аймгийн Жаргалан сумын авто замын ажилд 2,675,484.4 мянган төгрөг, Харгуй АЗЗА ТӨХК-д Өндөрхаан-Чойлбалсан чиглэлийн зам засахад 1,057,428.7 мянган төгрөг, Архангай АЗЗА ТӨХК-д аймгийн 100-н жилийн ойтой холбоотой аймгийн төвийн 2,2 км замын засахад 1,485,871.3 мянган төгрөг, Налайх АЗЗА ТӨХК-д Налайх-Тэрэлж чиглэлийн зам засах ажилд 1,604,187.0 мянган төгрөг олгохоор төлөвлөж, нийт 5,683,448.4 мянган төгрөгийг тус тус хуваарилж олгосон байна.	1	-					1	-
Улсын авто замын сан	Ховд АЗЗА ТӨХК-д гүйцэтгэл гараагүй ажилд өр үүсгэж бүртгэсэн байна.	1	-					1	-

Улсын авто замын сан	Захирагчийн ажлын албанаас НЗДТГ-ын баяр наадмын зардал руу хүй 7 худгийн замын нөхөөс хийх ажлын зардалд 67,145.0 мянган төгрөг шилжүүлсэн байхад УАЗС-ын байгалийн гамшиг, гэнэтийн осол, аюулын улмаас үүссэн авто замын эвдрэл, гэмтлийг засварлах санхүүжилтээс хурдан морины зам засах ажилд 53,915.8 мянган төгрөгийн зам засварын ажлын зардлыг давхардуулан олгосон байна.	1	53,915.8			1	53,915.8			
Улсын авто замын сан	МУЗГ-ын 2020 оны 131 дүгээр тогтоолоор баталсан Бүгд Найрамдах Беларус улсын засгийн газартай байгуулсан экспортын зээлийн гэрээний санхүүжилтээр "МАЗ-ын авто замын засвар, арчлалтын 42 ширхэг машин механизм нийлүүлэх" төслийн хүрээнд 2,816,373 еврогийн өртөгтэй 42 ширхэг машин механизмыг 20 АЗЗА компанид хүлээлгэн өгсөн байна. Дээрх хөрөнгийн дамжуулан зээлийн гэрээ хийгдээгүй учир хөрөнгийг бүртгэж аваагүй, үйл ажиллагаандаа ашигласаар байна.	1	-					1	-	
Улсын авто замын сан	МУЗГ, Кувейтийн сангийн хамтарсан төслийн хүрээнд 1997 онд 17 компанид 14 нэр төрлийн 164 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлж, 4,067,863 кувет динар-ын зээлийн өрийг Замын сангаас төлөхөөр Сангийн яамтай дамжуулан зээлийн гэрээ байгуулсан боловч санхүүгийн тайланд тусгагдаагүй байна. Дээрх хөрөнгийн элэгдлийн хугацаа дууссан, дамжуулан зээлийн төлбөр төлөгдөөгүй байна.	1	-					1	-	
УАЗС-ЫН НИЙТ ДҮН		6	53,915.8			-	2	53,915.8	4	-
БҮГД ДҮН		10	224,461.8	1	149,546.0		4	94,915.8	5	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 24,812,700.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

3.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
		Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал							
Улсын авто замын сан	Шилэн дансны цахим хуудсанд нийт мэдээлбэл зохих 171 мэдээллээс, 24,812,700.0 мянган төгрөгийн 123 мэдээллийг огт мэдээлээгүй байна.	1	24,812,700.0			1	24,812,700.0
Улсын авто замын сан	Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй	1	-	1	-		
Дүн		2	24,812,700.0	1	-	1	24,812,700.0